

Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах, усны нөөцийг зүй зохистой хэрэглээнд шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл “Улаанбаатар хотын хүн амын ундны усны нөөц”-ийн тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшингийн илтгэлийг хэлэлцээд ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Хатан –Туул” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

2. Улаанбаатар хотын усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалт, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг хатуу мөрдөж ажиллах.

3. Туул голын урсац бүрэлдэх эх, түүний цутгал голуудын эхэд мод тарьж ойжуулах арга хэмжээг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.

4. Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн дээд эх үүсвэрийн тэжээгдлийн муж, хамгаалалтын бүсэд баригдсан аялал жуулчлал, амралтын газруудыг бохир ус цэвэрлэх байгууламжтай болгож, хог хаягдал, бохирын усыг хатуу хянах.

5. Улаанбаатар хотын газрын доох гүний усны хяналт, шинжилгээний сүлжээг өргөтгөх, мэдээллийн сан байгуулах.

6. Туул, Сэлбэ, Дунд голын бохирдлыг бууруулсны үндсэн дээр голуудын дагуух эргийн тохижилт, үйлчилгээний ажлыг гүйцэтгэж, иргэдийн амралт, чөлөөт цагийг ая тухтай өнгөрүүлэх, аялах нөхцлийг бүрдүүлэх.

7. Иргэн, аж ахуйн нэгж, зуслангийн айл өрхийн ус хангамжид ашиглаж

байгаа төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийг цэгцэлж, төвлөрсөн шугаманд шат дараалан холбох.

8. Дулааны цахилгаан станц, үйлдвэр, үйлчилгээний ус хангамжид газрын доорх гүний ус ашиглахыг хориглох арга хэмжээг шат дараалан авах.

9. Шинээр барьж буй суурьшлийн бүсүүдэд цэвэрлэх байгууламжийг төлөвлөж орчин үеийн бохир ус цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэх.